

2019 ОНД БАЯН-УУЛ СУМАНД 50 ГА ТАЛБАЙД ШИЛМҮҮСТ МОДООР ОЙЖУУЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН АЖЛЫН ДААЛГАВАР,

2019.01.23

Хэрлэн сум

	Ажлын шалгуур
Ойжуулалтын ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд	“Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх” чиглэлээр БОАЖЯ-аас олгогдсон мэргэжлийн байгууллагын эрхтэй, тарьц суулгацын нөөцтэй, ажлын туршлагатай орон нутгийн ААН байна, /Ойн нөхөрлөлтэй түншилж болно/
	Ойжуулалтын ажил хийх мэргэжлийн боловсон хүчинтэй байх ба ойн инженер-1, ойн техникч-2, ойжуулагч-3 ба түүнээс дээш, энэ чиглэлийн ажлын дадлага туршлагатай ажилтнуудтай байна. /нотлох баримтаар баталгаажуулсан байх/
	Стандартын тарьц, суулгацын нөөцтэй байх /тарьцын тоо, MNS:6140-2010 стандарт хангасныг актаар нотолсон байх/
	1га талбайд чанарын 1 дүгээр зэргийн шилмүүст төрлийн модны стандартын шаардлага хангасан тарьц 2500 ширхгээс доошгүйг тарих
	Өмнө жилүүдэд хийсэн ойжуулалтын ажил болон адил төстэй бусад ажлын акт, тодорхойлолт, гэрээний хувийг хавсаргах
	Тарьсан тарьц суулгацын амьдралыг 3 жилийн хугацаанд бууруулахгүй байх төлөвлөгөөг Сум дундын Ойн ангиар батлуулсан байх
	Ойжуулалтын ажил хийх болон таримал ойг цаашид арчлах, хамгаалах талаар захирал болон ерөнхий инженерийн баталгаажуулсан технологийн карттай байх.
	Газрын хөрс боловсруулах МТЗ-80 трактор, ПКЛ-70 анжис мод тарих колесовын царил, жоотуу, хүрз, усалгааны емкость 2,5 тонн, хувин, усалгааны хоолойнууд зэрэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмжтэй байна. /техник тоног төхөөрөмжийг нотлох баримтаар баталгаажуулсан байх/
Бэлтгэл ажил	Ойжуулах ажлын технологийн картыг боловсруулж Сум дундын Ойн ангиар хянуулсан байх
	Ойжуулах талбайг өөрийн хөрөнгөөр цэвэрлэж бэлтгэн, ойн цэвэрлэгээний ажил хийгдсэн талбайд ойжуулалтын ажил хийсэн байна.Сум дундын Ойн ангиар тусгаарлуулсан байх, өнцгүүдэд шон босгож, талбайд шан гаргаж, чиг тэмдэг тавьсан байх
	Тарих тарьц суулгацыг ачих буулгах, түр хадгалах технологи, горим мөрдсөн байна.
Үндсэн ажил	Талбайн хөрсийг боловсруулж шан татах арга, технологи мөрдөж тарьцыг 30 см гүнд тарина. /Шангийн өргөн 40 см, гүн 30 см, шан хооронд 4 м байна/
	Суулгах тарьцыг тариалтанд бэлтгэн хавсралт зураг 1-д заасан тарилтын технологиор эгнээ хооронд 4 м, ургамал хооронд 1 метр

зайтайгаар тарина. /Тарьц нь чанарын 1 дүгээр зэргийн шаардлага хангасан байх/
Технологийн картын дагуу тарьц тарьж, усалж арчлан хамгаална
Усалгааг хийж чийгийг барих арга хэмжээг авч хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.
Ойн ангийн инженер, байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагчаас арга зүйн заавар зөвлөгөө авч ажлыг гүйцэтгэсэн байна.
Ойжуулах талбайд тарьц тарьсны дараах усалгааг системтэйгээр хийсэн байна.
Анх тарьснаас хойш 3 жилийн турш гүйцэтгэгч аж ахуйн нэгж ургах чадваргүй болсон тарьц, суулгацыг ухаж авч нөхөн тарилт хийж ургуулсан байна.
Ойжуулсан талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга бүхий пайз 4ширхэг, тендерт ажлын танилцуулга бүхий 2 х 2 м хэмжээтэй самбар төмрөөр 1 ширхгийг бэлтгэж бетонон суурьт бэхэлж анхааруулах самбар, булангийн тэмдэгжүүлтийг журмын дагуу хийх байрлуулсан байна.
Тарьсан ойг хүний сөрөг нөлөө, мал амьтны хөлөөс хамгаалах арга хэмжээ авч, мөн гал түймрээс хамгаалах шороон зурвас татна./5-7м өргөнтэй тойруулан хагална/
Ойжуулалтын ажлын хувийн хэргийг хөтлөн, талбайн зургийн хамт ажил хүлээж авах комисст заавал танилцуулна.

2019 ОНД БАЯН-УУЛ СУМАНД ШИЛМҮҮСТ МОДООР ОЙЖУУЛАХ АЖЛЫН ХЭМЖЭЭ ТАЛБАЙН БАЙРШИЛ


2019.01.23

Хэрлэн сум

Сумын нэр	Газрын нэр	Ойн хэсэглэлийн дугаар	Талбайн хэмжээ /га/	Багцын дугаар	Талбайн байршил
Баян-уул	Ар дархинт	28	50		Баян-Уул сумын төвөөс хойш 48 км-т байрлана. Газрын налуу, хотгор гүдгэр бага, ХАА-ын трактор, техник явах усалгаа хийх боломжтой.
Дүн			50 га		

БАЙГАЛЬ ОРЧИН

Дорнод аймгийн Баян-Уул сумын нутагт
2019 онд ойжуулалт хийх талбайн байршлын зураг



1 CM-т = 2,977 Метр

Нийт 50 га талбай

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР